



**АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/223

Эрдэнэбулган сум

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх
дотоод аудитын хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.12, 4.13, 4.14 дэх хэсэг, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хорооны нарийн бичгийн даргаар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын ахлах дотоод аудитор (А.Буяндэлгэр)-ыг томилсугай.

3.Дотоод аудитын хорооны дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөхийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Дотоод аудитын хорооны гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Архангай аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын хороог шинэчлэн байгуулах тухай” А/605 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД

652000100024

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 17-ний өдрийн
17/223 дугаар захирамжийн хавсралт



ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| № | Гүйцэтгэх үүрэг | Албан тушаал | Овог нэр |
|---|-----------------|--|----------------|
| 1 | Хорооны дарга | Архангай аймгийн Засаг дарга | Б.Цэрэннадмид |
| 2 | Хорооны гишүүн | Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын дарга | Д.Нэргүйбаатар |
| 3 | Хорооны гишүүн | Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга | Ц.Батцэцэг |
| 4 | Хорооны гишүүн | Орон нутгийн өмчийн газрын дарга | Х.Ганхуяг |
| 5 | Хорооны гишүүн | Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн | Б.Пүрэвдавуу |
| 6 | Хорооны гишүүн | ММНБИ-ийн Архангай салбарын дарга | Ж.Мөнхбат |
| 7 | Хорооны гишүүн | Аймгийн ИТХ-ын төлөөлөгч | Г.Галсандорж |

---oOo---